

БАЯНХОНГОР АЙМГИЙН АВЛИГЫН ЭСРЭГ ОЛОН НИЙТИЙГ СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2023 оны 06 дугаар сарын 09

Номгон

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2023 оны А/48 дугаар захирамжаар батлуулан, аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний зардлаас 8,0 сая/төг, Аймгийн гэмт хэргэг, зөрчлөөс урьдчилан ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 5,0 сая/төг төсөвлөн 6 зорилтын хүрээнд 27 арга хэмжээ төлөвлөн ажиллаж байна.

1.1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах ажлын хүрээнд:

Авлигын эсрэг хууль болон бусад хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэн ажиллах, авлига, ашиг сонирхол, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх зорилгоор Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нар, агентлаг, байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудын ажилтан, албан хаагчид/мэргэжилтэн/ зэрэг 90 гаруй алба хаагчдад 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдөр "Шинээр батлагдсан хууль, тогтоомжийн хэрэгжилт", "Монгол улсын Засгийн газрын 2023 оны "Авлигын эсрэг болгон зарлах тухай" 49 дүгээр тогтоол", "Meduuleg.iaас.mn цахим систем ашиглалт, бодлогын баримт бичиг, хуулт тогтоомж, тогтоол шийдвэрийн тайлагналт" зэрэг сэдвүүдээр Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Төрийн цахим үйлчилгээний хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтсүүд чиг үүргийн хүрээнд мэдээлэл, сургалт зохион байгуулсан.



1000 гаруй алба хаагчдад "Нийтийн албан тушаалтанд тавих хориглолт

Баян-овоо сумын төрийн албан хаагч, иргэдэд тусгай хөтөлбөрийн дагуу "Нийтийн албан тушаалтанд тавих хориглолт хязгаарлалт" сэдвээр 70 төрийн албан хаагчийг хамруулан авлигын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэн мөн Төлөвлөгөөт сургалтын хүрээнд нийт 20 байгууллагын

хязгаарлалт", Монгол улсын Засгийн газрын 2023 оны "Авлигын эсрэг болгон зарлах тухай" 49 дүгээр тогтоол, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль зэрэг сэдвүүдээр сургалтад хамруулж мэдлэг ойлголтыг нэмэгдүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс Монголын Өмгөөлөгчдийн холбооны Баянхонгор аймгийн салбартай хамтран иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор иргэдэд хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх "Хуульчийн Про Боно өдөр-2023" өдөрлөгийг зохион байгуулж АЗДТГ-ын дэргэдэх Төрийн нэгдсэн үйлчилгээний төв, 3-р баг, 2-р баг, 4-р баг, 1-р баг гэсэн байршлуудыг сонгон алслагдсан 3 баг, аймгийн төвийн хүний хөдөлгөөн их худалдааны төв гэсэн хувилбараар сонголт хийж тогтсон байранд 2 байршилд, 3 байршилд зөөврийн сууц ашиглан нүүдэллэн ажиллав.

САНАЖИЛАН ЗОХИОН БАГУУЛАГЧ
ХАМТРАН ӨРӨНДӨГН БАГУУЛАГА












“ХУУЛЬЧИЙН ПРО БОНО ӨДӨР-2023”

2023.05.01

НИЙСЛЭЛ БОЛОН 21 АЙМГИЙН
ИРГЭДЭД ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ҮНЭ
ТӨЛБӨРГҮЙ ӨГӨХ ӨДӨРЛӨГ БОЛНО

Байршил: Төрийн үйлчилгээний нэгдсэн төв /Аймгийн захиргаа/
2-р багийн төв
Амьчуулын цагаан идээний зөхын гадна талбай
Арван мянгат Нураг хайрхан дэлгүүрийн гадна талбай

Иргэн Та 2023 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 10:00-17:00 цагийн хооронд хүрэлцэн ирж хууль, эрх зүйн зөвлөгөө мэдээллийг үнэ төлбөргүй аваарай.

Өдөрлөгт АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс, Баянхонгор аймгийн Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч, Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг, Прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Хууль зүйн туслалцааны төв, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Өмгөөлөгчдийн зөвлөл, Нотариатчидын танхимын салбар, Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, эмэгтэйчүүдийг хамгаалах Нэг цэгийн үйлчилгээний төв хамтран ажиллаж иргэдэд байгууллагын үйл ажиллагаа, чиглэл чиглэлийн хуулийн танилцуулга хийж, хууль зүйн зөвлөгөө, баримт бичгийн хуулбарыг батлах зэрэг үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлж ажилласан нийт 525 иргэнд үйлчилснээс 174 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө, 351 иргэнд тараах материал танилцуулга түгээж тус тус өөрсдийн үйл ажиллагааны чиглэлээр хууль зүйн зөвлөгөөг өгсөн байна.

Аймгийн хэмжээний нийт, сум байгууллагуудын дунд “Шударга удирдагч ил тод байгууллага” аяныг жилийн хугацаатай зарлан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Аяны хүрээнд: Мэдээллийн самбарт авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчилсан төрлийн зурган мэдээлэлүүдийг тухай бүр байршуулсан ажиллалаа.



Мөн Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Нэгдье” аяны хүрээнд аймгийн төрийн болон төрийн бус байгууллагуудыг өөрсдийн цахим хуудсанд “Нэгдье” постер зургийг байршуулан мөн аймгийн автобусны буудал болон аймгаас орох зам дагуу байрлах самбарт авлигатай тэмцэх газраас бэлтгэн ирүүлсэн постер зургийг байршуулан. Аймгийн нэгдсэн веб хуудас болох <https://bayanhongor.gov.mn/>, болон “Нээлттэй засаг нэг баянхонгор” page- хуудасуудаар иргэд олон нийтэд хүргэн ажиллаж байна 2000 иргэний хандалтыг аваад байна.



1.2. Шинээр батлагдсан хуулиуд болон боловсруулж буй хуулийн төсөл, бусад холбогдох хууль тогтоомжийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, сурталчилгааны ажлыг зохион байгуулахад тухай бүр дэмжлэг үзүүлэх хүрээнд:

Төлөвлөгөөт сургалтын хүрээнд: Нэгдсэн эмнэлэг, Шүүхийн шийдвэргүйцэтгэх газар, “Чандмань Баянхонгор” ХК, “Цэвэр хот” ОНӨҮГ, Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК, “Сум дундын ойн анги” ОНӨААТҮГ, Авто тээврийн үндэсний төвийн Баянхонгор дахь салбар, “Баянхонгор Эрчим хүч” цахилгаан түгээх ХХК, “Баянхонгор тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ, зэрэг 20 байгууллагын давхардсан тоогоор 1000 гаруй төрийн албан хаагч иргэд танхимын болон цахим сургалтыг зохион байгуулсан.

Захиалгат сургалтын хүрээнд: Баян-овоо сум Төрийн алба хаагчид болон, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Насан туршийн боловсролын төв зэрэг нийт 140 гаруй алба хаагчдад “Нийтийн албан тушаалтанд тавигдах хориглолт хязгаарлалт” сэдвээр сургалтыг зохион байгуулсан.

Хууль тогтоомжийн сурталчилгааг орон нутгийн телевиз, аймгийн www.bayankhongor.gov.mn цахим хуудас, хэлтсийн PAGE хуудас болон мэдээллийн самбараар сурталчлан, хялбаршуулсан гарын авлага бэлтгэж иргэд, төрийн байгууллагуудад түгээн ажиллаж байна. АТГ-аас ирүүлсэн телевизийн богино хэмжээний 14 шторк, хэвлэн олшруулах 6 төрлийн материалууд, 73 групп, 61 пэйж хуудсанд байршуулсан. Мэдээллийн самбарт авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчилсан 14 төрлийн 64 зурган мэдээллийг байршуулан 3000 гаруй иргэний хандалтыг авсан байна.

1.3. Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх ажлын хүрээнд:

Тухайн оны төсвийн төсөл хагас жилээр оруулах мэдээллүүдийг хуулийн цаглабарт хугацаанд нь Шилэн дансанд байршуулж, мэдээллийн ил тод байдлыг хангаж, олон нийтэд мэдээлж ажилласан.

Мөн аймгийн www.bayankhongor.gov.mn цахим хуудасны шилэн данс цэсэнд тухайн жилийн төсөв, төсвийн гүйцэтгэл, аудитын дүгнэлт, зөвлөмж, орон нутгийн хөгжлийн сан, болон холбогдох бусад мэдээллийг тогтмол байршуулж байна.

1.4. Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах ажлын хүрээнд:



Архины тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт ирүүлсэн 48 иргэнээс баримт бичгийн шаардлага хангасан 46 иргэний тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 2 иргэний тусгай зөвшөөрлийн нэр өөрчилсөн байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт бүхий өргөдлийн маягтыг bayankhongor.gov.mn цахим хуудсанд байршуулсан.

Мөн түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт бүхий өргөдлийн маягтыг bayankhongor.gov.mn цахим хуудсанд байршуулсан.

Боловсролын байгууллагуудаас энэ оны эхний хагас жилийн байдлаар тусгай зөвшөөрлийн хугацааг шинээр болон сунгах тухай хүсэл ирүүлээгүй болно

Эрүүл мэндийн чиглэлийн байгууллагуудаас тус оны эхний хагас жилийн байдлаар тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж үйл ажиллагааныхаа тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулсан 6, шинээр авсан 4, хаяг байршилд өөрчлөлт оруулсан 2, хүчингүй болгосон 2 байна.

Тус чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгаж, олон нийтэд танилцах боломжоор ханган ажиллаж байна.

1.5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах ажлын хүрээнд:

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2023 оны II дугаар улирлын байдлаарх бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тодотгон батлагдсан төлөвлөгөөнд Олон улсын төслийн санхүүжилт, Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 49 нэр төрлийн 10.6 тэрбум төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөгдсөн.

Энэ оны тайлант хугацаанд 10.6 тэрбум төгрөгийн 49 нэр төрлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр зарласан бөгөөд аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2023 оны II дугаар улирлын бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тодотгосон төлөвлөгөө 85%-ийн биелэлттэй байна. Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор 2023 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг Засгийн газрын худалдан авах ажиллагааны “tender.gov.mn” болон Баянхонгор аймгийн “bayankhongor.gov.mn”, umch.bkh.gov.mn сайтуудад байршуулан олон нийтэд сурталчилсан.

Мөн 2023 оны нийт 30 тендерийн урилгыг tender.gov.mn, bayankhongor.gov.mn сайт, umch.bkh.gov.mn, “Зууны мэдээ” сонинд тухай бүр нийтлүүлсэн.




Тухайн тендерт оролцогчийн шалгарсан болон шалгараагүй шалтгаан, үр дүнг Засгийн газрын tender.gov.mn сайтад тогтмол оруулж ажилласан.

Тухайн тендерт оролцогчийн шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсны дараа гэрээг цахим системд оруулна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам Худалдан авсан бараа,

ажил, үйлчилгээний тайланг жилийн эцсийн байдлаар бүр цаг хугацаанд нь гаргаж Bayankhongor.gov.mn майтад байршуулж ажиллав.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журамд заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг жилийн эцсийн байдлаар цаг хугацаанд нь гаргаж Bayankhongor.gov.mn, umch.bkh.gov.mn сайтад байршуулж ажилласан. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, хяналт шалгалтын дүнг Bayankhongor.gov.mn, umch.bkh.gov.mn сайтад тогтмол байршуулж ажилласан.



Орон нутгийн өмчийн газраас 2023 оны 02 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд Төрийн худалдан авах ажиллагаанд мэргэшүүлэх "А3" сертификат олгох сургалтыг "Худалдан авах ажиллагааны сургалт судалгааны төв" ТББ-тай хамтран зохион байгууллаа. Сургалтад аймгийн бүх сумдаас төрийн алба, төрийн бус байгууллагууд, иргэд, аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл нийт 116 хүн хамрагдснаас 65% буюу 76 хүн шалгалтанд тэнцэж, шинээр төрийн худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сертификат авлаа.




ажиллаж байна.

Тендер шалгаруулалт явуулах явцад гарсан аливаа санал гомдлыг шийдвэрлэн ажиллахаас гадна холбогдох байгууллагад шилжүүлж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу шийдвэрлэн

Энэ оны хагас жилийн байдлаар 30 үнэлгээний хороо байгуулагдсан 46 шийдвэр гаргасан бөгөөд шийдвэр бүрийг цахим хуудсанд байршуулж, үнэлгээний

хорооны бүрэлдэхүүн тус бүрт иргэний төлөөлөл, төрийн бус байгууллагын төлөөллийг байнга оролцуулан ажиллаж урамшуулал олгохоор төлөвлөж байна.

Худалдан авах ажиллагааны өдөр тутамын ажил болон зарлагдаж байгаа тендерийн мэдээлэл болон сар, улирал, жилийн тайланг тухай бүр иргэд болон аж ахуйн нэгжүүдэд мэдээллийг ил тод байлгах үүднээс тухай бүр байгууллагын мэдээллийн самбарт, Bayankhongor.gov.mn, umch.bkh.gov.mn сайтуудад байршуулан ажиллаж байна.



1.6. Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дүрын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах ажлын хүрээнд:



Нийгмийн хариуцлагын хүрээнд Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн авлигын талаарх мэдээллийг зорчигчдод сонсгож, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулахаар

хот хоорондын автобус үйлчилгээний байгууллагууд нэгдэн хамтран ажиллах гэрээ байгууллаа.

Тус ажил нь "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд АТГ-аас ирүүлсэн болон орон нутагтаа бүтээсэн авлигыг үл тэвчих, энэ зорчигч тээвэрлэх үйлчилгээ үзүүлдэг "Баянхонгор Тээвэрчин" ХХК, "Лотот" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан олон



нийтэд хүргэхээр 1 сарын хугацаатай гэрээ байгуулан долоо хоногийн 4 өдөрт өдрийн 3 удаагийн нийт 36 удаагийн давтамжтайгаар Баянхонгор-Улаанбаатар-Баянхонгор чиглэлд 45 хүний суудалтай автобусанд зорчигчдод сурталчилсан.

1.7. Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах ажлын хүрээнд:

Иргэдэд нээлттэй ил тод, шударга байдлыг бий болгох зорилт тавин сул орон тооны зарыг

- Аймгийн www.bayanhongor.gov.mn цахим хуудас
- Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn цахим хуудас

- www.facebook.com/ Баянхонгор аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөл/ групп,
- Орон нутгийн телевиз,
- www.facebook.com /Нээлттэй засаг-Нэг Баянхонгор/ зэрэг цахим хуудсуудад мэдээллийг тухай бүр байршуулан ажиллаж байна.

Төрийн албаны зөвлөлийн Баянхонгор аймаг дахь салбар зөвлөлөөс төрийн жинхэнэ алба хаах сонирхолтой иргэнийг сонгон шалгаруулж, нөөц бүрдүүлэх зорилгоор нийтдээ 3 удаагийн зар тавьж 33 сул орон тоог нөхсөн

Аймгийн засаг дарга Удирдах ажилтнуудтай хамтран ажиллах батламж олгон, авлигагүй ажиллах талаар баталгаа гаргав:

Аймгийн Удирдах ажилтны зөвлөгөөнийг АЗДТГ-аас зохион байгуулж, 20 сумын Засаг дарга, агентлагын дарга нартай Ажил орлоготой иргэн, Архигүй эрүүл өрх, Авлигагүй шударга төрийн төлөө хамтран ажиллах 10 зүйл бүхий үүргийг хүлээлгэсэн хоёрт талын гарын үсэг бүхий БАТЛАМЖИЙГ олголоо.



Батламжид Аймгийн Засаг дарга түүний Тамгын газраас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, албан үүргээ хангалтгүй биелүүлэх, төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулах, архидан согтуурах, хууль зөрчин аливаа томилгоо хийх, иргэний язгуур эрхийг хөндөх, ёс суртахууны доголдол гаргах, авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдох тохиолдолд Засаг даргын үүрэгт ажлаас шууд татгалзаж зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэхээр талаар заасан.

1.8.Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах ажлын хүрээнд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн 70440001 дугаарын утсаар, www.bayanhongor.gov.mn вэб сайтаар, info@bayankhongor.gov.mn цахим шуудангийн хаягаар, Засаг даргын Тамгын газрын байр болон төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн байранд байрлах санал авах хайрцгаар мөн аймгийг Засаг дарга долоо хоног бүрийн Пүрэв гарагт иргэдийн хүлээн авч уулзаж, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Өргөдөл, гомдол, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн бичгээр болон цахимаар тус тус иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч байна. Энэ оны 06 сарын байдлаар нийт 70 өргөдөл ирснээс 68 гомдол хүсэлтийг хуулийн хугацаанд

шийдвэрлэн ажиллалаа.

Төрөөс иргэдэд олгодог бүх төрлийн үйлчилгээг цахим хэлбэрээр үнэ төлбөргүй хүргэх, төрийн байгууллагатай холбоотой гомдол саналыг цахим хэлбэрээр хүлээн авч иргэдэд хүргэж үйлчилгээг ойртуулах зорилгоор байгаа аймгийн төрийн байгууллагуудын дунд e-office системийг нэвтрүүлж тухайн байгууллагатай холбоотой өргөдөл гомдлыг цахимаар хүлээн авч түргэн шуурхай шийдвэрлэх нөхцөл бүрдсэн.

1.9. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах ажлын хүрээнд:

Аймгийн гэмт хэргэг, зөрчлөөс урьдчилан ажлыг зохицуулах салбар зөвлөл, аймгийн Засаг даргын Тамгын газрын хууль, эрх зүйн хэлтэс Прокурорын газартай хамтран аймгийн хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөнийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулсан.



Тус зөвлөгөөнөөр Авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдийг таслан зогсоох, үр дагаврыг нь арилгах арга хэмжээ авч, авлигын эсрэг сургалт, сурталчилгаа зохион байгуулах талаар Тус зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжид тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах зорилгоор 2023 оны 02 дугаар сараас эхлэн Аймгийн Засаг даргын Тамгын газрын баруун жигүүрт байрлалтай "Нэг цонх"-ны үйлчилгээний төвөөр үйлчлүүлж буй иргэдээс сэтгэл ханамжийн судалгааг авч хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Баянхонгор Аймгийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс сургагч багшийн зардлыг шийдвэрлүүлэн орон нутагтаа 6 сургагч багш шинээр бэлтгэхээр Авлигатай тэмцэх газарт санал өгч сургалтад хамруулахаар болсон. Уг сургалтад хамрагдсан сургагч багш нар нь сумдыг бүсчлэн авч сургалт нөлөөллийн арга хэмжээг тогтмол зохион байгуулахаар төлөвлөж байна.

Иргэдийн мэдэх эрхийн хүрээнд Аймгийн Засаг даргын Тамгын газрын баруун жигүүрт байрлалтай "Нэг цонх"-ны үйлчилгээний төвийн зааланд "Шударга

ёс хөгжил дэвшилд" нэртэй авлигын талаарх мэдээллийг түгээх, хүлээн авах самбар ажиллуулж мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна. Тус 110 мэдээллийн самбарыг сум байгууллагууд самбартаа 110 дугаарын утас мэдээллийг байршуулан иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах хайрцаг ажиллуулж байгаа бөгөөд тайлант хугацаанд он гарсаар тус хайрцагт авлигатай холбоотой санал, гомдол ирүүлээгүй байна.

ТАНИЛЦСАН
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

ХЯНАСАН:
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.САРАНГАРАВ

НЭГТГЭСЭН
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН *Э.Золзаяа* Э.ЗОЛЗАЯА

ДҮГНЭХ ХУУДАС

2022 оны 06 дугаар сарын 09

Номгон

№	Зохион байгуулсан арга хэмжээ	Тоон үзүүлэлт	Хамруулсан хүний тоо
1.	АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байдал;	Авлигатай тэмцэх газрын пэйж хуудас, АТГ-Олон нийтийн төв албан ёсны хуудсуудад байршуулсан мэдээллийг хэлтсийн фэйсбүүк хуудсаар 15 төрлийн мэдээг түгээж 3000 хандалт авч, 143 удаа түгээн ажилласан. АТГ-аас ирүүлсэн телевизийн богино хэмжээний 14 шторк, хэвлэн олшруулах 6 төрлийн материалууд, 73 групп, 61 пэйж хуудсанд байршуулсан. Мэдээллийн самбарт авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчилсан 14 төрлийн 30 зурган мэдээллийг байршуулан ажилласан.	3000 иргэний гаруй хандалтыг авсан байна.
2.	АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, youtube суваг) зэргээр сурталчилсан байдал;	Авлигатай тэмцэх газрын пэйж хуудас, АТГ-Олон нийтийн төв албан ёсны хуудсануудад байршуулсан мэдээллийг хэлтсийн фэйсбүүк хуудсаар 15 төрлийн мэдээг түгээж 3000 хандалт авч, 143 удаа түгээн ажилласан. АТГ-аас ирүүлсэн телевизийн богино хэмжээний 14 шторк, хэвлэн олшруулах 6 төрлийн материалууд, 73 групп, 61 пэйж хуудсанд байршуулсан. Мэдээллийн самбарт авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчилсан 14 төрлийн 30 зурган мэдээллийг байршуулан ажилласан.	Фэйсбүүк хуудсаар 15 төрлийн мэдээг, 143 удаа түгээн ажилласан.
3.	Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг дэмжиж ажилласан байдал;	Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Нэгдье” “Нэгдье” аяны хүрээнд аймгийн төрийн болон төрийн бус байгууллагуудыг өөрсдийн цахим хуудсанд “Нэгдье” постер зургийг байршуулан мөн аймгийн автобусны буудал болон аймгаас орох зам дагуу байрлах самбарт авлигатай тэмцэх газраас бэлтгэнэ ирүүлсэн постер зургийг байршуулсан иргэд олон нийтэд хүргэн 2 мянга гаруй иргэдэд сурталчлан ажилласан.	2 мянга гаруй иргэдэд сурталчлан ажилласан.
4.	Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг орон нутаг, салбартаа зохион байгуулсан байдал;	“Нэгдье” аяны хүрээнд аймгийн төрийн болон төрийн бус байгууллагуудыг өөрсдийн цахим хуудсанд “Нэгдье” постер зургийг байршуулан мөн аймгийн автобусны буудал болон аймгаас орох зам дагуу байрлах самбарт авлигатай тэмцэх газраас бэлтгэнэ ирүүлсэн постер зургийг байршуулсан иргэд олон нийтэд хүргэн сурталчлан ажилласан.	иргэд олон нийтэд хүргэн сурталчлан ажилласан.
5.	Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах мэдээллийн булан, самбар тогтмол ажиллуулсан байдал;	Иргэдийн мэдэх эрхийн хүрээнд Аймгийн Засаг даргын Тамгын газрын баруун жигүүрт байрлалтай “Нэг цонх”-ны үйлчилгээний төвийн зааланд “Шударга ёс хөгжил дэвшилд” нэртэй авлигын талаарх мэдээллийг түгээх, хүлээн авах самбар ажиллуулж мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна. Тус 110 мэдээллийн самбарыг бусад сум байгууллагууд хуучин самбартаа 110 дугаарын утас мэдээллийг байршуулан ажиллаж байна. Мөн тус самбарт иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах хайрцаг ажиллуулж байна. Одоогоор тус хайрцагт авлигатай холбоотой санал, гомдол ирүүлээгүй мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна.	110 мэдээллийн самбарт авлигын мэдээллийг тогтмол байршуулдаг.

6.	Авлигын эсрэг сургалтын санал, захиалга өгсөн байдал;	Авлигатай тэмцэх газарт 2023 оны 03 дугаар 03-ны өдрийн 2/318 албан бичгээр сургалтын захиалга өгсөн.	
7.	Авлигын эсрэг сургалтад шинээр томилогдсон албан хаагчаа хамруулсан байдал;	Авлигын эсрэг сургалтад шинээр т Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нар, агентлаг, байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудын ажилтан, албан хаагчид/мэргэжилтэн/ зэрэг 90 алба хаагчийг хамруулсан.	90 албан тушаашаалтан хамрагдсан
8.	Авлигын эсрэг давтан сургалтад албан хаагчдаа хамруулсан байдал;	АТГ-аас Авлигын эсрэг сургалт болон давтан сургалтыг зохион байгуулаагүй.	
9.	Иргэд, олон нийт, хүүхэд залуучуудад зориулан авлигын эсрэг сургалт, сурталчилгаа зохион байгуулсан байдал;	ЕБС-ын сургуулиудад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйн мэдлэг олгох сургалт зохион байгуулах ажлын хүрээнд "Нууцтай байх эрх" сэдвээр Аймгийн Прокурорын газрын зөрчлийн прокурор М.Билгүүтэй "Алгоритм" дунд сургуулийн 11, 12 дугаар ангийн 45 сурагчдад Хууль зүйн туслалцааны төвийн улсын ахлах өмгөөлөгч Г.Дуламсүрэн "Гэгээн сумади" сургуулийн 10,11,12 дугаар ангийн 110 сурагчдад тус тус сургалт зохион байгуулсан.	155 сурагч хамрагдсан.
10.	Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, мөрдөгчийн мэдэгдэл, зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд арга хэмжээг зохион байгуулсан байдал;	Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, мөрдөгчийн мэдэгдэл, Зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион байгуулсан ажлын хариу тайланг тухай бүр хүргүүлэн ажиллалаа.	Хариуг хугацаанд нь хүргүүлсэн
11.	Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга уриа, аянд нэгдсэн байдал;	Аймгийн хэмжээнд "Шударга удирдагч ил тод байгууллага" аяныг нэгж жилийн хугацаатай өрнүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Мөн авлигын талаарх мэдээллийг зорчигчдод сонсгож, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулахаар хот хоорондын автобус үйлчилгээний байгууллагууд болох "Баянхонгор Тээвэрчин" ХХК, "Лотот" ХХК-уудтай хамтран ажиллах гэрээ байгуулан 1 сарын хугацаатай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.	Төрийн бус байгууллагын оролцоог хангасан
12.	Авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр шинэ шийдэл, сайн туршлага, технологи нэвтрүүлэх замаар хүнд суртал чирэгдлийг багасгах зэрэг үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулсан байдал;	Өргөдөл гомдол хүлээн авах, цаасан суурьтай баримтыг халах, сумдын засаг даргын захирамжийг тухай бүр хянаж хуулийн үндэслэлийг хянаж саналаа өгөх төрийн үйл ажиллагааг түргэн шуурхай ил тод нээлттэй явуулах зорилгоор e-office системийг нэвтрүүлэн ажиллаж байна.	E-office системийг нэвтрүүлсэн

6-дугаар зүйлийг дүгнэх хуудас				
/Авлигын эсрэг хууль, Шилэн дансны тухай хууль Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд зааснаар доорх мэдээллүүдийг цахим хуудас дээрээ байршуулж, иргэд үзэж, танилцах боломжоор хангах/				
д/д	Мэдээллүүд	Байршуулсан	Байршуулааг үй	Тайлбар
15	Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулсан байх, төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг хүлээн авах боломжийг бүрдүүлсэн байдал	Bayanhongor.gov.mn хаягт тухай бүр байршуулсан	-	-
16	Дээрх асуудлаар иргэд, олон нийт, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцсон байдал;	Bayanhongor.gov.mn цахим хуудсаар иргэдээс ирүүлсэн санал хүсэлтэд хариу өгч ажиллаж байна.	-	-
17	Тухайн жилийн төсөв /1 дүгээр сарын 10-ны дотор/	www.shilendans.gov.mn -д тухай бүр байршуулан ажиллаж байна	-	-
18	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл /4 дүгээр сарын 1-ний дотор/	www.shilendans.gov.mn -д тухай бүр байршуулан ажиллаж байна	-	-
19	Дараа жилийн төсвийн төсөл /8 дугаар сарын 15-ны дотор/	www.shilendans.gov.mn -д тухай бүр байршуулан ажиллаж байна	-	-
20	9.1.4.2.Жилийн эцсийн санхүүгийн тайлан /5 дүгээр сарын 1-ний дотор/	www.shilendans.gov.mn -д тухай бүр байршуулан ажиллаж байна	-	-
21	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /5 дүгээр сарын 1-ний дотор/	www.shilendans.gov.mn -д тухай бүр байршуулан ажиллаж байна	-	-
22	Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаар мэдээлэх /өөрчлөлт орсноос хойш ажлын 14 хоногт/	www.shilendans.gov.mn -д тухай бүр байршуулан ажиллаж байна	-	-
23	Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох /татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл/	www.shilendans.gov.mn -д тухай бүр байршуулан ажиллаж байна	-	-
24	Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)	Eitimongolia цахим хуудсанд байршуулсан	-	-
25	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)	www.shilendans.gov.mn -д тухай бүр байршуулан ажиллаж байна	-	-
26	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, ер, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр)	www.shilendans.gov.mn -д тухай бүр байршуулан ажиллаж байна	-	-

27	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилт, явц байдлын талаарх мэдээлэл;	www.shilendans.gov.mn -д тухай бүр байршуулан ажиллаж байна	-	-
28	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	tender.gov.mn-д байршуулсан	-	-
29	Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга	tender.gov.mn-д байршуулсан	-	-
30	Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл /шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэл/	www.shilendans.gov.mn -д тухай бүр байршуулан ажиллаж байна	-	-
31	Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайлан	www.shilendans.gov.mn -д тухай бүр байршуулан ажиллаж байна	-	-
32	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүн	Bayankhongor.gov.mn хаягт тухай бүр байршуулсан	-	-
33	Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан (Бүтэн жилээр)	www.shilendans.gov.mn -д тухай бүр байршуулан ажиллаж байна	-	-
34	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр)	www.shilendans.gov.mn -д тухай бүр байршуулан ажиллаж байна	-	-
35	Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл /Бүтэн жил, сар бүр/ орон нутагт хамааралтай	www.shilendans.gov.mn -д тухай бүр байршуулан ажиллаж байна	-	-
36	Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Сар бүр) орон нутагт хамааралтай	www.shilendans.gov.mn -д тухай бүр байршуулан ажиллаж байна	-	-
37	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл (Тухай бүр)	-	-	-
38	Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/	Bayanhongor.gov.mn хаягт тухай бүр байршуулсан	-	-
39	Дээрх зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журам	Bayankhongor.gov.mn хаягт тухай бүр байршуулсан	-	-
40	Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл	Bayankhongor.gov.mn хаягт тухай бүр байршуулсан	-	-

	олгосон болон дуусгавар болох хугацаа			
41	Ажилтнуудын хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээлэл	Байгууллагын цахим хаяг болон албан хаагчдын ажлын өрөөний үүдэнд ажилтнуудын хариуцсан ажил, чиг үүргийг байршуулсан	-	-
42	Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээлэл	Төрийн байгууллагуудын ил тод байдал сайжирсан	-	-
43	Ёс зүйн дүрэм	Bayanhongor.gov.mn хаягт тухай бүр байршуулсан	-	-
44	Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдал /тушаал, захирамж/	Bayanhongor.gov.mn хаягт тухай бүр байршуулсан	-	-
45	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/, дүрэм, журам, заавар	Bayanhongor.gov.mn хаягт тухай бүр байршуулсан	-	-
46	Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийн үнэ, тарифын талаарх мэдээллийг хууль эрх зүйн үндэслэл журмын хамт байршуулах	Bayanhongor.gov.mn хаягт тухай бүр байршуулсан	-	-
47	Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт (Тухай бүр)	Тухай бүр байгууллагын дансанд бүртгэж мэдээлийн цахим хуудсанд бүртгэлжүүлэн ажиллаж байна.	-	-
48	Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн эсэх	Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн 70440001 дугаарийн утсаар, www.bayanhongor.gov.mn вэб сайтаар, info@bayanhongor.gov.mn хаяг байгууллагын бичиг хэргээр дамжуулан хүлээн авч байна.	-	-
49	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь	Bayanhongor.gov.mn цахим хуудсанд иргэдэд ил тод байдлаар байршуулсан	-	-
50	Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаарх мэдээлэл	Bayanhongor.gov.mn цахим хуудсаар иргэдээс ирүүлсэн санал хүсэлтэд хариу өгч ажиллаж байна.	-	-
51	Сул орон тооны зар /тухай бүр шинэчилсэн/	csc.gov.mn-д байгууллагуудаас ирсэн сул орон тооны мэдээллийг тухай бүр цахимд бүртгэн ТАЗ-д хүргүүлэн ажиллаж байна	-	-
52	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам	-	Хүний нөөцийн стратеги журам	Журамгүй

53	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт (Сар бүр)	Хүний нөөцийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг сар бүр өөрчилж мөн бүрэлдэхүүн хөдөлгөөнийг https://hr.csc.gov.mt цахим хаягт тогтмол бүртгэлжүүлдэг		
----	---	--	--	--

ХЯНАСАН
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГА



Д.САРАНГАРАВ

НЭГТГЭСЭН:
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

ГСТ7121 0320100002

Э.Золзаяа Э.ЗОЛЗАЯА